



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 9/174

Баян-Өндөр сум

**Ээлжит хуралдаан
зарлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.6 дахь хэсгүүд, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ын 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хуралдааны дэгийг шинэчлэн батлах тухай” тогтоолын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит V хуралдааныг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр танхим цахим хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолуудын зарим заалтад өөрчлөлт оруулах саналын тухай;
2. Сүм, хийдийн хугацаа сунгах тухай;
3. Чиглэл өгөх тухай;
4. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоох тухай;
5. Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай;
6. Баян-Өндөр сумын Цагаанчулуут (Найрамдал) баг, 49-53 дугаар гудамж гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай;
7. Газрын харилцааны талаар 2025 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийн биелэлт, 2026 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай;
8. Зөвшөөрөл олгох тухай;
9. Аймгийн 2026 оны төсөв батлах тухай;
10. Хурлын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлангийн тухай;

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит V хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

6125070390

3.Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны
өдрийн 411/27 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ V ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит V хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

XI/20-ны дотор

Ажлын алба

2. “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолуудын зарим заалтад өөрчлөлт оруулах саналын тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

3. “Сүм, хийдийн хугацаа сунгах тухай” асуудлын илтгэл, шийдвэрийн төсөл боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

4. “Чиглэл өгөх тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

5. “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоох тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

6. “Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

7. “Баян-Өндөр сумын Цагаанчулуут (Найрамдал) баг, 49-53 дугаар гудамж гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

8. “Газрын харилцааны талаар 2025 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийн биелэлт, 2026 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

9. “Аймгийн 2026 оны төсөв батлах тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

10. “Зөвшөөрөл олгох тухай” илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

11. “Хурлын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлангийн тухай” асуудлын илтгэл, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/20, XI/27, XII/03-ны дотор Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

12. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

XI/27, 28-ны дотор Холбогдох Хороод

13. Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

XII/03-ны дотор Ажлын албаны дарга Ш.Ганболд

АЖЛЫН АЛБА